



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 34

Жаргалант

Г Зохицуулах хороо байгуулах тухай Г

Даян дэлхийн хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал хөтөлбөрөөс Монгол Улсад олгож буй буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Дэлхийн банк, Үйлдвэр хөдөө аж ахуйн яамтай хамтран тус суманд “Хөдөө аж ахуйн маркетинг” төсөл хэрэгжих болсонтой холбогдуулан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн сумын Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Төслийн хэрэгжилтийг бодлогоор хангах, шийдвэр гаргах сумын зохицуулах хорооны бүрэлдэхүүнийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга	Д.Сайнбилэг	-Сумын Засаг дарга
Гишүүдэд	Д.Дашхүү	- МЭҮТ-ын дарга
	Д.Дэнсмаа	-ИТХ-ын төлөөлөгч
	Ч.Цэдэвсүрэн	-1 дүгээр багийн Засаг дарга
	Г.Алтанцэцэг	-Халамжийн нийгмийн ажилтан
	Д.Мөнхжаргал	-“Нутгийн цагаан шим” хоршооны тэргүүлэгч
Нарийн бичгийн дарга		-Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний багийн төлөөлөл /төслийн талаас/

Хоёр. Төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн уялдаа холбоог хангаж ажиллахыг сумын зохицуулах хорооны дарга /Д.Сайнбилэг/-д даалгасугай.

ДАРГА



Д.ГАНТӨМӨР

1513177



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 35

Жаргалант

┌ Шагналд тодорхойлох тухай ┐

Төрийн одон медалиар шагнуулахаар С.Ноов, Ж.Бямбажав, Д.Дэнсмаа нарын ажил байдлын тодорхойлолт, хамт олны хурлын тэмдэглэл, анкет зэргийг авч хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг.Боловсролын салбарт оруулсан хувь нэмрийг үнэлж С.Ноовыг “Хөдөлмөрийн хүндэт медаль”, төрийн байгууллагад он удаан жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан хөдөлмөрийг үнэлж Ж.Бямбажавыг “Хөдөлмөрийн хүндэт медаль” Д.Дэнсмааг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар тодорхойлсугай.

Хоёр. Дээрхи шагналд тодорхойлсон хүмүүсийн тодорхойлолт, материалуудыг Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж өгөхийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргаас хүссүгэй.

ДАРГА



Д.ГАНТӨМӨР

1513178

togtool-2014



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 36

Жаргалант

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын 3.3 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангаас санхүүжих төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Дарга	Д.Сайнбилэг
Нарийн бичгийн дарга	С.Жаргалсайхан
Гишүүд	Д.Энхбаатар
	Т.Пүрэвжав
	Н.Дэмбэрэл
	Ц.Мөнхтунгалаг
	Д.Далхаа

2. Сангийн хөрөнгийг журмын дагуу төсөл сонгон шалгаруулан, зээл олгон хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга /Д.Сайнбилэг/-д даалгасугай.

3. Сумын ИТХ-ын хуралдааны 2013 оны 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1516184



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 37

Жаргалант

Хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэхь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг 2014 оны 07 дугаар сарын 30 -ны өдрийн 10 цагт хуралдуулсугай.

Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

1. Сумын Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн
2. Төсвийн тодотгол
3. Сумын Засаг даргатай холбоотой Монгол Ардын Намын бүлгийн санал

Гурав. Хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн асуудлуудыг сайтар бэлтгэн материалыг нэгээс доошгүй хоногийн өмнө төлөөлөгчдөд тараах ажлыг зохион байгуулахыг ИТХ-ын ажлын алба, сумын Засаг дарга /Д.Сайнбилэг/-д даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513181



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 38

Жаргалант

Малын үржлийн ажлыг сайжруулах  
дэд хөтөлбөр батлах тухай

“Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэхь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Малын үржлийн ажлыг сайжруулах” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Сайнбилэг/, мал эмнэлэг үржлийн тасгийн дарга /Д.Дашхүү/ нарт даалгасугай.



ДАРГА *[Signature]* Д.ГАНТӨМӨР

1513185

togtool-2014

**ЖАРГАЛАНТ СУМЫН МАЛЫН ҮРЖЛИЙН АЖЛЫГ  
САЙЖРУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР /2013-2018 он/**

**Нэг. Мал аж ахуйн өнөөгийн байдал:**

2012 оны сумын хэмжээний мал тооллогын дүнгээс үзэхэд азарга 207, бух 257, хуц 245, ухна 205 бүгд 925 хээлтүүлэгч байгаа нь нэг хээлтэгчид азарга 9,7, бух 27,2, хуц 75, ухна 77 ноогдож хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан байна. Бог малын хээлтүүлэгчийн үзлэг, чанар ангилалт, ээмэгжүүлэлт, үржлийн бүртгэлийн ажлын байдлаар үзэхэд стандарт бус хээлтүүлэгч их байгаа нь хээлтүүлэгч дутагдалтайн зэрэгцээ чанарын хувьд өнөөгийн шаардлага, эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсч сүргийн бүтэц, малын төрөл хоорондын харьцаа, малчид малын чанарт анхаарахгүй бог малын 47.2 хувийг ямаан сүрэг эзэлж байгаа нь уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж хуурайшилт эрчимтэй явагдаж, бэлчээр хомсдож, ургамлын бүтэц өөрчлөгдөж, бэлчээр талхлагдахад ихээхэн нөлөөлж байна.

**Хоёр. Хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл:**

Уур амьсгалын өөрчлөлт улс орны нийгмийн хөгжлийн чиг хандлага зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг мал аж ахуйн гаралтай хүрэлцэхүйц чанартай хүнсээр хангах, нэг малаас ашиглах ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэх, хуваарьтай ашиглах, бүтээмж ашиг шим өндөртэй мал үржүүлэх шаардлага гарч байна. Монгол улсын Их хурлаас “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг баталж мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлэх, малын үржлийн ажил үйлчилгээг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ гэж заасан нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болж байна.

**Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа:**

3.1 Монгол малын ашигтай онцлог шинж чанарыг тухайн үүлдэр, омог хэвшлийн баталгаажсан цөм сүргээр бататган сайжруулж, удам зүй сонгон үржүүлэгийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж биологийн боломжийг бүрэн ашиглах

3.2 Бэлчээрийн монгол малыг орон нутагт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омог хэвшлийн цөм сүргийн малаар сайжруулах

3.3 Малчдыг бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэр оруулах

3.4 Хонийг Байдраг үүлдрийн үржлийн цөм сүрэг /суурь/ бий болгон тухайн сууриас үржлийн хээлтүүлэгч бойжуулан малчдад худалдан суурь бүрт зөвхөн Байдраг үүлдрийн хээлтүүлэгч ашиглан өсгөж үржүүлэх. Байдраг үүлдрийн хонины мах, ноосны гарцыг нэмэгдүүлэхийн тулд Баяд үүлдрийн хуцаар нэг удаа цус шингээх эрлийзжүүлэг хийнэ.

3.5 Мал сүрэгт ямааны эзлэх хувийн жинг барьж эхний ээлжинд өөр аймаг, сумын дасан зохицох чадвартай, ашиг шим өндөртэй хээлтүүлэгчийг авч өсгөн хээлтүүлэгт ашиглан ноолуурын гарцыг нэмэгдүүлэх

3.6 Сарлаг үхрийг өөр дотор нь хээлтүүлэгч сонгон суурь хооронд 1-2 жил болгон сольж ашиглах, улмаар зэргэлдээ Гурванбулаг, Хангай, Чулуут сумтай гэрээ байгуулан бухан бяруу солилцооны журмаар авч үржилд ашиглах мах, сүүний гарцыг нэмэгдүүлэх зорилгоор сарлаг үхрийн 10 хувиас хэтрүүлэхгүйгээр хайнагжуулах ажлыг хийх

3.7 Адуун сүргийг өөр дотор нь сонгон үржүүлэхийн зэрэгцээ гадны аймаг, сумаас хурдан удмын азарга, гүү худалдан авах замаар сайжруулах

#### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн**

4.1 Хөтөлбөрийг 2013 оноос 2018 он хүртэлх хугацаатай хэрэгжүүлж дараах үр дүнд хүрсэн байна.

4.1.1 Мал аж ахуй эрхлэх таатай орчин нөхцөл бүрдэнэ.

4.1.2 Малын чанар дээшилж үржлийн ажил сайжирна

4.1.3 Байдраг үүлдрийн хонины цэвэр цөм сүрэг бий болж мах, ноосны гарц нэмэгдэнэ.

4.1.4 Орон нутагт мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний жижиг дунд үйлдвэрлэл бий болно.

4.1.5 Малчдын орлого нэмэгдэнэ

#### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт:**

5.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, мэргэжил арга зүй, зохион байгуулалтаар сумын Засаг дарга түүний тамгын газар, мал эмнэлэг үржлийн тасаг хангаж малчид, малчны хоршоод хэрэгжүүлэн ажиллана.

5.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохицуулах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөл, мал эмнэлэг үржлийн тасаг шууд хариуцан ажиллана.

5.3 Хөтөлбөрийн заалтыг багийн Засаг дарга, мал эмнэлэг үржлийн аж ахуйн нэгжүүд, малчид, мал бүхий иргэд хэрэгжүүлэн ажиллана.

5.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллана

**Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт:**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах санхүүгийн эх үүсвэрийг ашиглана.

- А. Малчид, малчдын бүлэг, хоршооны өөрийн хөрөнгө
- Б. Орон нутгийн хөгжлийн сан
- В. Зээл тусламж, байгууллага иргэдийн хандив.

**Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд**

7.1 Эрх зүйн баримт бичиг

7.2 Сургалт, үзүүлэх сургууль, үзэсгэлэн худалдаа, тэдгээрт хамрагдсан хүний тоо

7.3 Малын төрөл бүрээр гарсан бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт

7.4 Байдраг хонины тооны өсөлт

7.5 Оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ

7.6 Бусад холбогдох төсөл хөтөлбөр

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_





**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 39

Жаргалант

Төрийн дээд шагналд тодорхойлох

Тухай

Монгол улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Жаргалант сумын 2-р багийн иргэн өндөр настан Н.Даваажанцанг Монгол улсын төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар тодорхойлсугай.

Хоёр. Холбогдох материалыг Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Аймгийн засаг дарга Д.Жаргалсайханд хүргүүлж уламжилсугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1513191



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 41

Жаргалант

Төлбөр тогтоох тухай

Монгол улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.14 дахь заалт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Өлзийт өндөр 2 дугаар багийн нутаг Биндэръяа хөх нууранд тавьж өсгөсөн Зэвэг, Хадран загас үржиж Заг, Байдраг голоор ихээр тархсан тул иргэдэд ахуйн зориулалтаар барихад доорхи төлбөрийг мөрдсүгэй.

А. Зэвгэ загасыг 1 толгой тутамд Зэвгэ загасны экологи эдийн засгийн үнэлгээний 20 хувь буюу 3400 төгрөг.

Б. Хадран загасыг 1 толгой тутамд Хадран загасны экологи эдийн засгийн үнэлгээний 30 хувь буюу 1500 төгрөг.

Хоёр. Байдраг, Заг голд байдаг дээрх загаснуудын ангалтын хугацаа, төлбөр төлөлтөнд хяналт тавьж ажиллахыг Сумын засаг дарга Д.Сайнбилэг, БОХУлсын байцаагч Д.Далхаа нарт даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР

1510189



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 42

Жаргалант

Шагналд тодорхойлох тухай

Тус сумын 2 дугаар багийн малчин Ж.Рагчаасүрэнг “Улсын сайн малчин”-д тодорхойлох тухай Жаргалант сумын Засаг даргын хүсэлт, Өлзийт өндөр 2 дугаар багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоол, тэмдэглэл зэргийг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 70 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.6 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Жавхан овогтой Рагчаасүрэнг “Улсын сайн малчин”-аар шагнуулахаар тодорхойлсугай.

2.Ж.Рагчаасүрэнг “Улсын сайн малчин”-аар шагнуулахаар тодорхойлсон тодорхойлолт, материалуудыг дэмжин Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн мэдүүлж өгөхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргаас хүссүгэй.

ДАРГА

Д.ГАНТӨМӨР

1513193

togtool-2014